



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

“Азиапасифик пропертис” ХК-ийн
үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 51, 62.1.6 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Азиапасифик пропертис” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 352,770 ширхэг хувьцааг нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3,527,700 ширхэг энгийн хувьцаанд хувааж, тус компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Азиапасифик пропертис” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн бүртгэлд холбогдох өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000010